



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Булган аймаг	Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn
2023 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.2 Албан шаардлага .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.14 № 63  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

ОРХОН СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ДАРГА  
Н.ОТГОНЗАЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Жилийн эцэст бараа материалын тооллого хийж тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-д заасан заалтыг зөрчин эрхлэгчийн худалдан авах ажиллагааны сургалтын төлбөрийг төлсөн ба санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

006020066

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Булган аймгийн Орхон сумын соёлын төв нь сургууль 1 хөтөлбөр, 6 арга хэмжээний хүрээнд нийт 116,335.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 115,313.3 мянган төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 99.1 хувьтай байна.

### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Орхон сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч нь 2022 онд Орхон сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 86 хувийн биелэлтэйгээр тайлагнасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,045.00</b>	<b>7,811,988.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	1,042,178.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	1,042,178.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	1,042,178.00
31211	Төрийн сангийн харилцах	-	1,042,178.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,045.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,045.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	6,769,810.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	-	6,769,810.00
35410	Бичиг хэргийн материал	-	95,500.00
35420	Аж ахуйн материал	-	299,000.00
35450	Барилгын засварын материал	-	43,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	6,332,310.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>135,077,699.09</b>	<b>135,437,007.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	135,077,699.09	135,437,007.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	119,103,699.09	117,993,007.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	92,747,527.00	92,747,527.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,202,227.86)	(14,839,604.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,139,116.20	31,375,916.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,815,954.96)	(14,592,297.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,820,376.40	22,220,376.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,228,193.65)	(13,604,544.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,183,502.00	3,183,502.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,094,328.84)	(1,591,751.04)
39217	Ном	12,553,882.80	13,093,882.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,974,000.00	17,444,000.00
39301	Програм хангамж	300,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(240,000.00)	(270,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,914,000.00	15,914,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>135,080,744.09</b>	<b>143,248,995.02</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>73,094,285.79</b>	<b>81,262,536.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	73,094,285.79	81,262,536.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,914,000.00	15,914,000.00
51101	Өмч: - төрийн	15,914,000.00	15,914,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(96,802,920.62)	(88,634,669.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(96,802,920.62)	(96,802,920.62)
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,168,250.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	153,983,206.41	153,983,206.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>73,094,285.79</b>	<b>81,262,536.72</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>77,692,100.00</b>	<b>122,835,710.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>6,480,310.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	6,480,310.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,480,310.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	278,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,201,810.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>77,692,100.00</b>	<b>116,355,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	94,035,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	94,035,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	77,692,100.00	21,520,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,692,100.00	21,520,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>98,237,862.40</b>	<b>124,149,459.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>98,237,862.40</b>	<b>124,149,459.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	93,464,496.36	97,434,693.07
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	44,723,243.00	53,311,715.00
210101	Үндсэн цалин	44,723,243.00	53,311,715.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,776,939.96	6,561,935.00
210201	Тэтгэврийн даатгал	4,014,994.73	4,602,895.81
210202	Тэтгэмжийн даатгал	447,232.43	541,517.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,785.97	433,213.70
210204	Ажилгүйдлийн даатгал	86,993.33	85,612.74
210205	Эрүүл мэндийн даатгал	869,933.50	898,695.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,938,053.00	19,119,101.00
210301	Гэрэл, цахилгаан	175,590.00	284,285.00
210302	Түлш, халаалт	19,762,463.00	18,834,816.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	315,000.00	267,650.00
210401	Бичиг хэрэг	73,000.00	37,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	92,000.00	80,650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	390,000.00	205,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	78,000.00	-
210604	Урсгал засвар	312,000.00	205,400.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	54,000.00	56,000.00
210702	Дотоод албан томилот	54,000.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,647,900.00	3,123,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,647,900.00	3,123,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,619,360.40	14,789,192.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,525,210.00	471,700.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,094,150.40	14,317,492.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,773,366.04	26,714,766.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	26,319,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,551,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	768,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	395,466.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	395,466.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,773,366.04	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,773,366.04	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(20,545,762.40)</b>	<b>(1,313,749.07)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(20,545,762.40)</b>	<b>(1,313,749.07)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>77,692,100.00</b>	<b>116,633,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>278,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	278,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	278,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	278,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>77,692,100.00</b>	<b>116,355,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	94,035,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	94,035,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	77,692,100.00	21,520,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,692,100.00	21,520,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>77,743,600.00</b>	<b>110,436,922.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>77,743,600.00</b>	<b>110,436,922.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>72,970,233.96</b>	<b>83,722,156.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	44,010,892.00	53,308,670.00
210101	Үндсэн цалин	37,592,401.20	42,149,467.00
210102	Нэмэгдэл	6,418,490.80	7,423,043.00
210104	Урамшуулал	-	3,736,160.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,492,335.96	6,561,935.00
210201	Тэтгэврийн даатгал	4,564,735.96	4,556,011.24
210202	Тэтгэмжийн даатгал	481,900.00	535,995.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	385,500.00	425,972.10
210204	Ажилгүйдлийн даатгал	96,400.00	110,023.34
210205	Эрүүл мэндийн даатгал	963,800.00	933,932.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,210,406.00	19,119,101.00
210301	Гэрэл, цахилгаан	175,590.00	284,285.00
210302	Түлш, халаалт	19,034,816.00	18,834,816.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	325,000.00	286,150.00

210401	Бичиг хэрэг	45,000.00	55,500.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	80,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>380,000.00</b>	<b>478,900.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	230,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	248,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>54,000.00</b>	<b>56,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	54,000.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,329,400.00</b>	<b>3,411,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,329,400.00	3,411,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>168,200.00</b>	<b>500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	168,200.00	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,773,366.04</b>	<b>26,714,766.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>26,319,300.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,551,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	768,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>395,466.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	395,466.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,773,366.04</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,773,366.04	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(51,500.00)</b>	<b>6,196,978.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>5,154,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>5,154,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>5,154,800.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	2,754,800.00
223001	Бусад хөрөнгө	-	2,400,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(5,154,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(51,500.00)</b>	<b>1,042,178.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>1,042,178.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,900,458.30	153,983,206.41	(76,308,658.22)		155,575,006.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,900,458.30	153,983,206.41	(76,308,658.22)	-	155,575,006.49

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(20,494,262.40)		(20,494,262.40)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,900,458.30	153,983,206.41	(96,802,920.62)	-	135,080,744.09
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	77,900,458.30	153,983,206.41	(96,802,920.62)	-	135,080,744.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,900,458.30	153,983,206.41	(96,802,920.62)	-	135,080,744.09
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	8,168,250.93		8,168,250.93
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,900,458.30	153,983,206.41	(88,634,669.69)	-	143,248,995.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	119,055,400.00	115,196,256.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	119,055,400.00	110,041,456.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	92,736,100.00	83,722,156.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	53,600,700.00	53,308,670.00
210101	Үндсэн цалин	39,286,700.00	42,149,467.00
210102	Нэмэгдэл	9,783,500.00	7,423,043.00
210104	Урамшуулал	4,530,500.00	3,736,160.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,700,000.00	6,561,935.00
210201	Тэтгэврийн даатгал	4,556,000.00	4,556,011.24
210202	Тэтгэмжийн даатгал	536,000.00	535,995.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	428,800.00	425,972.10
210204	Ажилгүйдлийн даатгал	107,200.00	110,023.34
210205	Эрүүл мэндийн даатгал	1,072,000.00	933,932.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,184,400.00	19,119,101.00
210301	Гэрэл, цахилгаан	350,000.00	284,285.00
210302	Түлш, халаалт	18,834,400.00	18,834,816.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	825,000.00	286,150.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	55,500.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	50,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	80,650.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,400,000.00	478,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	230,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	248,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	58,000.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	56,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,968,000.00	3,411,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,968,000.00	3,411,400.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,000,000.00	500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	500,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	26,319,300.00	26,319,300.00

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,319,300.00	26,319,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,551,300.00	25,551,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>5,154,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	5,154,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,754,800.00
223001	Бусад хөрөнгө	-	2,400,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	119,055,400.00	115,833,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	97,535,200.00	94,035,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	97,535,200.00	94,035,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	21,520,200.00	21,520,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	21,520,200.00	21,520,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	278,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	278,500.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>1,042,178.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	5.00	5.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Орхон сумын Соёлын төв нь Ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, Соёлын өвийг өвлүүлэх, түүхийн үнэт зүйлсийг хадгалж хамгаалах үйл ажиллагаа явуулна гэж зорилгоо тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Орхон сумын Соёлын төв нь Төсвийн тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагад дотоод аудит, аудиторын чиг үүргийг дангаараа гүйцэтгэдэг батлагдсан орон тоо байхгүй бөгөөд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэлийг хамт олны хурлаар танилцуулан ажилладаг байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2 жил дутам хяналт шалгалт хийдэг бөгөөд тайлант хугацааг хамарсан шалгалтаар 371.6 мянган төгрөгийн 2 акт, 1 албан шаардлага, хүргүүлэн ажилласан байна.

Иймд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон Соёлын төв-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Булган аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн санхүүгийн тайлангийн бүртгэл хөтөлдөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,168.3 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	0	1,042.2	1,042.2
Авлага	3.0	0	-3.0
Бараа материал	0	6,769.8	6,769.8
Үндсэн хөрөнгө	135,077.7	135,437.0	359.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>135,080.7</b>	<b>143,249.0</b>	<b>8,168.3</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	135,080.7	143,249.0	
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>135,080.7</b>	<b>143,249.0</b>	<b>8,168.3</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн данс 1,042.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Соёлын төв нь улсын төсвөөс хувьсах зардал нь санхүүжиж, зарцуулаагүй мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэхгүй болсонтой холбоотой.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 0.0 болсон нь ажилчдаас авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 6,769.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь баланст бүртгэлгүй бусад хангамж материал буюу тайзны хувцас, жижиг хэрэглэл байна.

Мөн дээд шатны байгууллага болох Булган аймгийн Соёл урлагийн газраас 9,482,0 мянган төгрөгийн 3 төрлийн 22 ширхэг тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, төсвийн хөрөнгөөр 500,0 мянган төгрөгийн ном, 400.0 мянган төгрөгийн сунадаг шат, 680.0 төгрөгөөр гэрэлтүүлгийн удирдлага. 2,074.8 мянган төгрөгөөр зөөврийн компьютер, 1,500.0 мянган төгрөгөөр санхүүгийн программ тус тус аваад байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 145,460.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 0.00 мянган төгрөг, нийт зарлагыг 145,460.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих зардлыг 86,589.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 28,421.9 мянган төгрөг буюу 30,449.1 мянган төгрөгөөр бууруулж, 115,011.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан төсвийг бууруулж хянасантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,343.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 116335.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 94,835.2 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 21,520.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 278.5 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 115,313.3 мянган төгрөг буюу 97,09 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,042.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	64,715.9	64,051.9	664.0	98.97
2	80214 Уран бүтээл хийлгэх	3,000.0	2,921.8	78.2	97.4
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	26,319.3	26,319.3	0	100
4	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	800.0	500.0	300.0	62.5
5	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	19,484.4	19,484.4	0	100
6	80112 Нийтлэг үйлчилгээ	2,035.8	2,035.8	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт төсөв ороогүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 116,633.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,749.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага түлш халаалтын зардлыг 200.0 мянган төгрөгөөр нэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орхон сумын Соёлын төв нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан 6 удаагийн 2,874.0 мянган төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-д заасан заалтыг зөрчин эрхлэгчийн худалдан авах ажиллагааны сургалтын төлбөрийг төлсөн ба санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### **Шийдвэрлэсэн нь:**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-д заасан заалтыг зөрчсөн зөрчилд 80.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тухайн байгууллага түүвэрт хамрагдсан ба акт, албан шаардлага, зөвлөмж хүргэгдээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,769.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 6,769.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Албан шаардлага

Жилийн эцэст бараа материалын тооллого хийж тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгд лийг хангаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жилийн эцэст бараа материалын тооллого хийж тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй	1	6,769.8			1	6,769.8						
Дүн	1	6,769.8			1	6,769.8						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-д заасан заалтыг зөрчсөн	1	80.0	1	80.0				
Дүн								
Нийт дүн	1	80.0	1	80.0				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.